

Эрүүл мэндийн газрын 2022 оны ...дугаар
сарын ...-ны өдрийндугаар
албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Эрүүл мэндийн газар

2022.11.29

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин	Он	Түвшин	
Зорилт 2.2. Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ:								
1	Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.	УТ 885,3 сая	Хариу арга хэмжээний чадавх Нөөц бүрдүүлэлтийн хувь	2020	Хариу арга хэмжээний чадавх 75% Нөөц бүрдүүлэлт 50%	2022	Хариу арга хэмжээний чадавх 85% Эрүүл мэндийн байгууллаг уудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт 75%	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 5 арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж хэрэгжилт дунджаар 83,8 хувьтай байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг тайлант хугацаанд 30%-д хүргэхээр төлөвлөснөөс 34,2% болж зорилтот түвшинд хүрсэн. Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт өвчлөлийн 63.2 хувийг халдварт бус өвчлөл эзэлж өмнөх оноос 17.8 хувиар буурсан байна. Тайлант хугацаанд төсөл хөтөлб өрийн хүрээнд нийт 374,7 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгаас шийдвэрлэсэн. Гамшгийн үеийн чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, гамшагаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилын үеэр танхимын сургалт 3 удаа, мэргэжлийн ангийн дадлага сургуулилыг 4 удаа хийж, хээрийн эмнэлэг дэлгэж жагсаалын үзлэгт “Онц” үнэлгээгээр дүгнэгдсэн. ЭМГ-ын даргын А/09 дүгээр тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85% байна. Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг

								<p>нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 нэр төрлийн 289,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байна.</p> <p>2022 оны байдлаар хариу арга хэмжээний чадавх 90%-тай болсон нь өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 85%-тай, нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
2	Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.		Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	2020	38,1%	2022	40%	<p>Тайлант хугацаанд нийт 1203 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 85950 иргэнийг хамруулж, 40 төрлийн сурталчилгааны материалыг 11401 иргэнд түгээсэн байна. Цахим хуудаст 1145 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 1325643 иргэнийг мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвд улс болон орон нутгаас нийт 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2022 оны 05 дугаар сарын 01-нээс үйл ажиллагааг эхлүүлсэн. Тайлант хугацаанд хүүхдийн болон насанд хүрэгсдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд 18318/17%/ иргэн хамрагдсанаас 10028 иргэнд зөвлөгөө өгч, 2248 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна.</p> <p>2022 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 552542 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 187604 буюу 33,9 хувь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5,5%-аар буурсан байна. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 34,2% байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 70%</i></p>
3	Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны	УТ 1.5 тэрбум ОНТ 307.9	СӨЭМТ болон БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн	2020		2022	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног	<p>Тайлант хугацаанд лавлагаа шатлалд 34 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ашиглалт 90% байна. Орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг билиметр болон УВЧ аппаратаар хангасан. Жаргалант суманд</p>

	дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.	сая	хангалтын хувь		төхөөрөмжийн хангалтын хувь 85%		төхөөрөмжийн хангалтын хувь 90%	орон нутгийн хөгжлийн сангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын өрөөг бүрэн тохижуулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангахаар 241,5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж орон нутгийн Өмчийн газар тендер зарлан бүрэн нийлүүлэгдсэн. Эрүүл мэндийг дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмжөөр ханган урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг хийгдэж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2%, Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-д хүрч, өмнөх онтой харьцуулахад 13%-аар нэмэгдсэн байна. <i>Хэрэгжилт 100%</i>
4	Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ	ОУ төсөл хөтөлбөр 120,0 сая	Яаралтай тусламжийн чадавх Техник, тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2020	85% 75%	2022	90% 80-95%	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай тусламжийн хүлээн авах тасагт Жайка олон улсын хамтын ажиллагааны төслөөс 120 сая төгрөгийн 4D ЭХО аппарат, амилуулах өрөөнд суурин амьсгалын аппарат шинээр суурилуулсан. Ажиглах хяналтын хэсэгт телемедицины дэлгэцийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт байрлуулан лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй шууд холбогдож 30 иргэнд зөвлөгөө авсан. Шархны анхны цэгцлэлт хийх мэс заслын өрөөнд туяагаар гар ариутгагч, оёдлын иж бүрдэл 3 ширхгээр хангаснаар эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас сэргийлсэн. Яаралтай тусламжийн хүлээн авах тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85% болж өмнөх оны мөн үеэс 5%-аар нэмэгдэж, яаралтай тусламж үзүүлэх чадавх 90%-д хүрсэн. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас түргэн тусламжийн тасгийг тоноглол бүхий 1 автомашинаар хангаснаар 13 түргэн тусламжийн машин дуудлагад үйлчилж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламж үзүүлэх нэгжийг шинээр байгуулж амилуулах суурь тусламжийг үзүүлэх багийг томилон гардан үйлдлийн сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 2 удаа зохион байгуулж чадавхжуулсан. Тус нэгжүүдэд хяналтын монитор

								8, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 10, отсос 8, дефибрилятор 5 ширхгийг байрлуулсан ба хүчилтөрөгчийн гуурс нэг сарын нөөцтэй, амин чухал эм, тариа 1-2 сарын нөөцтэй байна. Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Жаргалант сумын эрүүл мэндийн төвд төрөх болон яаралтай тусламжийн иж бүрдлийн цүнхээр хангагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 95%, гардан үйлдлийн чадавх 89%-тай байна. Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасгийг нээн ажиллуулж багаж тоног төхөөрөмжөөр 100% хангасан. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн яаралтай тусламжийн нэгжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85%, гардан үзүүлэх чадавх 82%-тай байна. <i>Хэрэгжилт 100%</i>
5	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.		<u>БОЭТ-ийг</u> санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжсэн байна.	-	-	2022	Бие даасан хэлбэрт шилжсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх бэлтгэл хангах хүрээнд: - <u>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, ДЭМБ-тай хамтран</u> эмнэлгүүдийн хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн 2 удаагийн сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч нарыг хамруулсан. - <u>439 оношийн хамааралтай</u> бүлгээр санхүүжилт авахаар сонгон шалгаруулалтад тэнцэж, ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан. - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 эмч, 1 сувилагч, 1 тусгай мэргэжилтнийг шалгаруулж <u>ЭМЯ</u> болон <u>АТГ-д</u> материалыг хүргүүлсэн. - Хэрэглэгчийн төлөөллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ажилчдын цалинг 23%-аар нэмсэн. - КРІ үнэлгээ-ажилтан бүрийн ажлын үнэлгээ, ур чадварыг үнэлэх аргачлалын сургалт нэвтрүүлэхээр сургалтад чанарын албаны дарга, гишүүдийг хамруулсан. - Ажилчдын нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор 30 ажилтанд тус бүрд 20,0 сая төгрөгийн байрны урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлсэн.	

								<ul style="list-style-type: none"> - Өөрийн хөрөнгөөр 266,0 сая төгрөгөөр Дотрын тасгийн их засварын ажил хийгдсэн. - Халдварт, Сүрьеэгийн тасгийг нэгтгэсэн. - Зүрхний шигдээс, харвалтын нэгжийг шинээр зохион байгуулсан. - Мэс заслын II тасгийг 15 ортойгоор шинээр нээсэн. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 70%</i></p>
6	Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.		Алсын зайн оношилгооны техникийн хэрэгслийн хангалтын хувь	2020	17%	2022	25%	<p>Бүсийн оношилгооны төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн хамрагдсан. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд БОЭТ-ийн телемедициний алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтыг 33%-тай, суурь үзүүлэлтээс 16%-аар нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>
7	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.		Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт	2020	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 88%	2022	Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилтийг 90%	<p>Тайлант хугацаанд нийтийн үйлчилгээтэй 81 эмийн сан, 13 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан.</p> <p>49 эмийн санд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд дунджаар 90,1% үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,4%-аар сайжирсан байна. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт”-аар 6 байгууллагад хяналт хийхэд дунджаар 93,4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад</p>

								стандартын хэрэгжилт 5,3%-аар сайжирсан байна. Зөвлөмжийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудад хүргүүлж, хяналт тавин ажилласан. <i>Хэрэгжилт 100%</i>
8	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	ОНТ 60.0 сая	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь	2020 2020	12,5 8,0	2022 2022	13,0 9,0	Тайлант хугацаанд 2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 170 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 17.6% нь суралцсан. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор “Эмч” хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөө батлагдан, орон нутгаас 60,0 сая төгрөгийг шийдвэрлэж, хэрэгжилт 96%-тай байна. - Гамшиг нийгмийн цаг үеийн дотоод сургалтад 1031 эмч, ажилтныг хамруулсан. - Австри улсад сургалтад 1 эмч, Япон улсад сувилахуйн сургалтад 3 сувилагчийг хамруулсан. - Дэлхийн эмч болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлаар шилдэг 12 илтгэлийг шалгаруулсан. Судалгааны арга зүйн сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулсан. Эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, алдаршуулах хүрээнд ажил мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, теле нэвтрүүлэг 4, аян 2 удаа зохион байгуулж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. - Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд 70 төлөөлө, Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ой хүрээнд багш шавийн уулзалтад 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч, төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцсан. - Англи хэлний сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг

								<p>хамруулсан Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой гомдол бүртгэгдээгүй.</p> <p>- 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд хавдрын <u>маркер</u> тодорхойлж, 3 мэргэжилтнийг лавлага шатлалд илгээсэн.</p> <p>Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12,9% нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
Хэрэгжилтийн дундаж хувь 92,5%								

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН /2022 ОН/**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хүрэх түвшин (2025 он)	Хүрсэн түвшин 2022 он	Тайлбар
1	Хүн амын дундаж наслалт	жил	70.2	Төрөлтөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ	74	72.6	2021 оны жилийн эцсийн байдлаар хүн амын дундаж наслалт 72.6 буюу өмнөх оноос 0.26-аар өссөн.
2	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	тоо	2.9	15-49 насны нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлсэн дундаж хүүхдийн тоо	3.3	0.2	Нэг эмэгтэйд ногдох төрөлтийн нийлбэр коэффициент 0.2 байна.
3	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	13.3	2019 оны суурь түвшин	10.3	4.2	Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 тохиолдлоор буюу 8.4 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.
4	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промилль	23.0	2019 оны суурь түвшин	18.2	0	Эхийн эндэгдэл гараагүй.
5	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	98.9	2018 оны суурь түвшин	99	98.7	2022 оны эхний 10 сарын байдлаар товлолт дархлаажуулалтад 12152 хүүхэд хамрагдаж хамралтын хувь 98.7 хувь байна.
6	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	77.4	2019 оны суурь түвшин	87.0	37.7	2022 онд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 68673 хүн хамруулахаар төлөвлөснөөс эхний 10 сарын байдлаар 25909 /37.7%/ хүн хамрагдаж өмнөх оноос 3.3 хувиар буурсан байна

7	10,000 хүн амд вирус гепатитын өвчлөл	тоо	3.4	-	2.5	0	Вирус гепатитын өвчлөл бүртгэгдээгүй.
8	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	73.1	2019 оны түвшин	суурь 87.5	47.9	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 40-өөс дээш насны 33925 хүн хамруулахаар төлөвлөснөөс эхний 10 сарын байдлаар 16246 хүн хамрагдаж өмнөх оноос 8.6 хувиар буурсан.
9	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	30.0	2019 оны түвшин	суурь 70.0	28	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралт 28% байна.
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	90.2	2019 оны түвшин	суурь 93.2	96,8	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн эзлэх хувь 96,8% байна.
11	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь	хувь	98.1	2019 оны түвшин	суурь 99.3	99	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь 99% болж 0,5%-аар нэмэгдсэн.
13	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь	хувь	98.5	2019 оны түвшин	суурь 99.7	99	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь 99% болж өмнөх оноос 0,1%-аар нэмэгдсэн.
15	Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувь	хувь	0	2020 оны түвшин	суурь 50.0	-	Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувийг тооцож гаргаагүй байна.

СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН

С.ЭРДЭНЭЦЭЦЭГ